



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жинжир Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatkhural@parliament.mn
http://www.parliament.mn

2025.01.31 № 05

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

Төр, нийтийн өмчийн асуудлаар

1. Монгол Улсын Их Хурал "Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай" 27 дугаар тогтоолыг 2007 онд баталсан. Уг тогтоолын нэгдүгээр хавсралтаар ашигт малтмалын стратегийн орд газарт 16 ордыг хамааруулсан.

Тогтоолын хавсралтын нэгдүгээрт Өмнөговь аймаг дахь чулуун нүүрсний Таван толгойн орд газрыг "Тавантолгой" ХК, "Энержи Ресурс" ХХК, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлийн хэмжээнд нөөц тооцсон талбайг хамааруулна гэж заасан.

Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсын газрын гадаргуу болон түүний хэвлийд байгалийн байдлаараа оршиж байгаа ашигт малтмал төрийн өмч мөн" гэж, 4, 5 дахь хэсэгт стратегийн ач холбогдол бүхий ордод төрийн оролцоог тогтоох тухай зохицуулсан.

Түүнчлэн Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5-д "энэ хуулийн 5.4, 5.5-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох, ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулах эсэх тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх" гэж Засгийн газрын бүрэн эрхийг хуульчилсан байна.

Таван толгойн стратегийн орд нь Цанхи, Бортолгой, Бортээг, Оорцог, Ончхараат, Ухаахудаг гэсэн зургаан хэсгээс бүрдэж байгаа ба үүнээс "Энержи Ресурс" ХХК-ийн эзэмшиж буй Ухаахудагаас бусад хэсгийг ямар нэгэн хэлбэрээр Төрийн оролцоотой ашиглаж байгаа билээ.

Монгол Улсын Их Хурлын шийдвэрээр стратегийн орд газруудыг баталснаар анхны эзэмшигч аж ахуйн нэгжээс төрийн мэдэлд шилжүүлж авах ажиллагаа хийгдсэн ба Таван толгойн орд газрыг төрийн мэдэлд авахдаа Монгол Улсын Засгийн газар Ухаа

2025000004

худагийн орд газрыг "Энержи Ресурс" ХХК-д үлдээж гэрээ байгуулан тус ордод төрийн эзэмшлийг тогтоох асуудлаар дурдсан хуулийн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

2. Монгол Улсын Ерөнхий сайдын Бүгд Найрамдах Хятад Ард Улсад 2024 оны 11 дүгээр сард хийсэн айлчлалын үеэр Гашуунсухайт – Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлэх асуудлаар зөвшилцөх үед "Монголын Төмөр зам" ТӨХК нөгөө талаас консорциум гэх "Шэньхуа групп корпораци лимитед", "Энержи Ресурс" ХХК, "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Тавантолгой" ХК нарын хооронд 2013 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Бээжин хотноо "Харилцан ойлголцлын санамж бичиг" гэх, мөн Бүгд Найрамдах Хятад Ард Улсын "Шэньхуа групп корпораци лимитед" болон "Гашуунсухайт Төмөр Зам" ХХК /Хэлэлцээрт дурдсанаар "Жи Эс Ар" гэх/, "Хятадын Хөгжлийн банк Корпораци" хооронд "Ганцмод – Гашуунсухайт боомтын төмөр замын төслийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр" гэх баримт бичгүүдийг үйлдсэн ба хачирхалтай нь тухайн санамж бичиг, хэлэлцээр нь Засгийн газрын хэрэг эрхлэх газар болон Гадаад харилцааны яамны бичиг хэрэг, архивд бүртгэлгүй, гэрээ хийгдсэн асуудлаар тодорхой баримт, бичиг байхгүй гэсэн мэдээлэл нийтэд ил болсон.

Уг санамж бичигт Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхүйц хэмжээний ноцтой асуудлуудыг дурдсан нь Монгол Улсаас Гашуун сухайт боомт Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас Ганц модны боомт хооронд ачаа тээврийн төмөр замын бүтээн байгуулалтыг хийх, төмөр замын цариг 1435 мм стандартыг баримтлах, консорциумын зүгээс төмөр зам барих зардлыг хариуцаж ашиглалтад оруулсны дараа үнийг тохиролцон бэлнээр авах эсвэл Ухаа худаг – Гашуун сухайт чиглэлд баригдаж буй төмөр замыг ашиглалтад оруулж хариуцсан аж ахуйн нэгжийн хувьцаагаар тооцож төлбөрийг гүйцэтгэх, төлбөр гүйцэтгэх хүртэл хугацаанд хил хоорондын төмөр замын ашиглалт, тээврийн асуудлыг консорциум хариуцна гэсэн утга бүхий заалтуудыг тусгажээ.

3. Дээрх санамж бичиг байгуулагдсаны дараа Бүгд Найрамдах Хятад Ард Улсын "Шэньхуа групп корпораци лимитед" болон "Гашуунсухайт Төмөр Зам" ХХК /Хэлэлцээрт дурдсанаар "Жи Эс Ар" гэх/, "Хятадын Хөгжлийн банк Корпораци" хооронд "Ганцмод – Гашуунсухайт боомтын төмөр замын төслийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр" гэх баримт, бичгийг 2014 оны 8 дугаар сарын 21-ний өдөр байгуулжээ.

Уг хэлэлцээр нь 2013 оны 10 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан "Монголын Төмөр зам" ТӨХК болон консорциум гэх "Шэньхуа групп корпораци лимитед", "Энержи Ресурс" ХХК, "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Тавантолгой" ХК нарын хоорондын "Харилцан ойлголцлын санамж бичиг"-ийг баталгаажуулсан агуулгатай бөгөөд мөн зарим ноцтой заалтуудыг тусгасан байна. Тухайлбал, хэлэлцээрийн:

(А) хэсэгт Гашуунсухайт – Ганцмод боомтыг холбосон боомтын төмөр зам барих ажлыг консорциумын талуудын байгуулсан "Жи Эс Ар" буюу "Гашуунсухайт Төмөр зам" ХХК гүйцэтгэх, тус компанийн 49 хувийг "Шэньхуа групп корпораци лимитед" эзэмших,

(Б) хэсэгт төмөр замын төслийн санхүүжилтийн 30 хувийг "Жи Эс Ар" хариуцах үлдсэн 70 хувийн санхүүжилтийг Хятадын хөгжлийн банкны зээл хэлбэрээр гүйцэтгэх. Зээлийн барьцаанд "Жи Эс Ар" дахь бүх хөрөнгө болон Монголын талын компаниудын эзэмшлийн бүх хувьцааг "Шэньхуа групп корпорац лимитед" барьцаалах замаар баталгааг хангуулах,

Хэлэлцээрийн 2 дахь заалтад боомт хоорондын төмөр замыг 1435 мм бүхий нарийн цариг гэх стандартаар гүйцэтгэх, Хятадын хөгжлийн банкны зүгээс санхүүжилтэд 150 сая ам.доллар хүртэлх зээлийг арилжааны нөхцөлөөр олгох зэрэг болно.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдөр өргөн барьсан "Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт – Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай" тогтоолын төслийн танилцуулга хэсэгт Бүгд Найрамдах Хятад Ард Улсын "Чайна Энержи Групп" компаниас 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдөр "Хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалт, нүүрсний худалдаа, нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааг цогцоор шийдвэрлэх тухай хүсэлт ирүүлж "Хятадын тал нь боомтын төмөр зам барьсан хөрөнгө оруулалт 7,17 тэрбум юань, 10 жилийн хугацааны алдагдал 2.7 тэрбум; цаашид шаардлагатай нэмэлт хөрөнгө оруулалт 4.1 тэрбум юань зэрэг нийтдээ 13,97 орчим тэрбум юанийн алдагдал хүлээгээд байгаа" талаар, энэхүү алдагдсан боломжийн өртөгийг цаашид Бүгд Найрамдах Хятад Ард Улсын зүгээс дурдахгүй гэсэн агуулга бүхий утгатай байна.

Хоёр улсын хэлэлцээрийн асуудлын үед алдагдсан боломжийн өртгийг нөгөө талаас дурдаж байгаа энэхүү үйлдэл нь хувийн хэвшил төрийн эрх үүргийг дур мэдэн хэрэгжүүлэх замаар төр, нийтийн ашиг сонирхлын эсрэг тодорхой чиглэл, даалгаваргүйгээр санамж бичиг, хэлэлцээрийг байгуулснаас үүдэлтэй байх ба цаашилбал хөрш улсын найрсаг харилцаанд сэв суулгах хүртэл эрсдлийг үүсгэж болохоор байжээ.

4. Монгол Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор байгуулагдсан Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар хянан шалгах үүрэг бүхий түр хорооноос нотлох баримтыг шинжлэн судлах нийтийн сонсголыг зохион байгуулсан.

Тус сонсголоор Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 252 дугаар тогтоолоор Ухаахудаг – Гашуунсухайт чиглэлийн төмөр зам барих, ашиглах концессын эрхийг "Энержи Ресурс" ХХК-д өгсөн. Үүний дагуу Монгол Улсын Засгийн газар 2012 оны 5 дугаар сарын 31-ний өдөр "Энержи Ресурс" ХХК болон "Энержи Ресурс Рэйл" ХХК-тай "Ухаахудаг-Гашуунсухайт" чиглэлд төмөр замын суурь бүтэц барих-ашиглах-шилжүүлэх концессын гэрээг байгуулсныг 2012 оны 11 дүгээр

сарын 03-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор хүчингүй болгож "Монголын Төмөр зам" ТӨХК-д эрх, тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн.

Засгийн газрын 2012 оны 121 дүгээр тогтоолын 5 дахь хэсэгт тогтоолын хэрэгжилттэй холбогдуулан өмнөх тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан аж ахуйн нэгжтэй хэлэлцээ хийж "...төслийг хамтран хэрэгжүүлэх бүтэц, хөрөнгө оруулалтын хэмжээ, нөхцөлийг тохирох, энэ тогтоолын 4 дүгээр зүйлд заасан компаниудын төмөр замын төсөлд оруулсан хөрөнгө оруулалтын зардлыг 3 дугаар зүйлд заасан тусгай зориулалтын компанид оруулах хөрөнгө оруулалтад тооцож хувьцаа эзэмшүүлэх, эсхүл буцаан олгох талаар хэлэлцээ хийх", 6-д "Ухаахудаг-Гашуунсухайтын чиглэлд төмөр замын суурь бүтэц барих-ашиглах-шилжүүлэх концессын гэрээ байгуулаад байсан хуулийн этгээдийн уг чиглэлийн төмөр замын суурь бүтцийг ашиглан жилд тээвэрлэх ачааны хэмжээ бүхий тээврийн эрхийг олгох, одоогийн байдлаар ажил гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүдийг цаашид үргэлжлүүлэн ажиллуулах асуудлыг судалж шийдвэрлэх" гэсэн үүрэг даалгаврыг тухайн үеийн Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн сайдад үүрэг болгосон байна.

Дээрх шийдвэрийн хүрээнд Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 12 дугаар сарын 07-ны өдөр "Концессын гэрээ цуцалсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" 478 дугаар тогтоолыг гаргаж "Энержи Ресурс" ХХК болон "Энержи Ресурс Рэйл" ХХК-д Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Зам, тээврийн яамны хамтарсан ажлын хэсгийн тооцож баталгаажуулсан гүйцэтгэсэн ажлын өртөг болох 93,677,314,158 /Ерэн гурван тэрбум зургаан зуун далан долоон сая гурван зуун арван дөрвөн мянга нэг зуун тавин найм/ төгрөгийг Засгийн газрын 2012 оны 121 дүгээр тогтоол гарах үеийн ханшаар тооцон нийт 60,335,716.4 /Жаран сая гурван зуун гучин таван мянга долоон зуун арван зургаа/ ам.долларыг олгохоор тогтоожээ. Энэ нь Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт "Бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх ба энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлахыг хориглоно", 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт "Монгол Улсын хууль тогтоомжид хураамж, шимтгэл, хариуцлагын хэмжээг тодорхойлохдоо зөвхөн төгрөгөөр илэрхийлнэ" гэснийг илтэд зөрчөөд зогсохгүй хувийн хэвшилд ашигтайгаар давуу байдал олгосон үйлдэл гэж үзэж байна.

Түүнчлэн нийтийн сонсголын үеэр талуудын мэдээллийг сонсох үед гүйцэтгэсэн ажлын нийт өртгөөс 55 тэрбум төгрөгийн санхүүгийн анхан шатны баримт бичгийг гүйцэтгэгч гаргаж өгөөгүй тухай мэдээлэл дурдсан. Хэрэв энэ асуудал үнэн Засгийн газар ажлыг хүлээж авахдаа алдаа гаргасан эсвэл төрөөс зарласан аливаа ажилд нэг аж ахуйн нэгжид байнгын давуу байдал олгосон, Улсад их хэмжээний хохирол учруулсан онц ноцтой бүлэг гэмт хэргийн шинжтэй үйлдэл байхыг ч үгүйсгэхгүй юм.

Дээрх асуудлууд нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Монгол Улсын хилийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль зэргийг зөрчиж Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын бүрэн эрхэд халдсан Үндэсний аюулгүй байдалд учирч болох эрсдэлийг үүсгэсэн шинжтэй ноцтой үйлдлүүд байх тул Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолоор Ухаахудаг ордыг стратегийн ордод хамааруулсан. Иймээс Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хуульд заасан 34 ба түүнээс дээш хувийг төрийн мэдэлд авч нийт ард иргэдэд үр өгөөжийг хүртээх асуудлаар хийгдэж байгаа үйл ажиллагаа, төлөвлөгөөний талаар;

2. "Энержи Ресурс" ХХК компанийн өмнө гаргасан гэх ямар хэмжээний зардлын нөхөн олговорт Ухаахудагийн ордыг өгсөн болох, хуулийн ямар заалт үндэслэн нөхөн төлбөрийг мөнгөн хөрөнгөөр биш, нүүрсний ордоор төлсөн болох талаар;


3. Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын хуулиар олгогдсон эрхэд халдаж ямар нэгэн чиглэл, шийдвэргүйгээр гадаадын аж ахуйн нэгжтэй Улсын бодлого, эрх ашиг, Үндэсний аюулгүй байдалтай холбогдох асуудлаар байгуулагдсан "Харилцан ойлголцлын санамж бичиг", "Ганцмод – Гашуунсухайт боомтын төмөр замын төслийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр" гэх баримт бичгүүдийн тухай Улсын Их хуралд дэлгэрэнгүй мэдээлэх, уг баримт бичгүүдийг хариуцан хэрэгжүүлсэн, гарын үсэг зурсан холбогдох албан тушаалтан, аж ахуйн нэгжээс тодруулга авах;

4. Монгол Улсын Засгийн газар болон "Энержи Ресурс" ХХК болон "Энержи Ресурс Рэйл" ХХК хоорондын 2012 оны 5 дугаар сарын 31-ний өдөр байгуулагдсан "Ухаахудаг-Гашуунсухайт" чиглэлд төмөр замын суурь бүтэц барих-ашиглах-шилжүүлэх концессын гэрээг цуцалж оруулсан хөрөнгө оруулалтыг барагдуулах асуудлаар зөвшилцөхийг даалгасан Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 121 дүгээр тогтоолын 2, 4, 5, 6 дахь заалт, "Концессын гэрээ цуцалсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" 2015 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 478 дугаар тогтоолыг зүйл, заалт тус бүрээр нь задлан хэрэгжилт, үр дүнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлэх;

5. Засгийн газар 2015 оны 12 дугаар сарын 07-ны өдөр 478 дугаар тогтоол батлахдаа "Энержи Ресурс" болон "Энержи ресурс рэйл" ХХК-д олгосон 93,677,314,158 /Ерэн гурван тэрбум зургаан зуун далан долоон сая гурван зуун арван дөрвөн мянга нэг зуун тавин найм/ төгрөгийн төлбөрийг Засгийн газар хуулийн ямар үндэслэлээр ам.долларт шилжүүлэн тооцож 60.3 сая ам.доллар олгосон талаар;

6. Засгийн газар 2015 оны 12 дугаар сарын 07-ны өдөр 478 дугаар тогтоол батлахдаа "Энержи Ресурс" болон "Энержи ресурс рэйл" ХХК-д өгч байгаа төлбөрийг яагаад тогтоол баталж байгаа тухайн өдрийн ам.доллар төгрөгийн ханшаар тооцохгүй 2012 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн ханшаар (хувийн компанид ашигтай байдлаар) тооцож олгохоор шийдвэрлэсэн болох талаар зэрэг болно.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Ө.ШИЖИР